

**“Жангар” туулийн Хаан Сийр бодонгийн бүлгийн
хоёр зүйлийн уламжлал**

Түдэвийн БАЯСГАЛАН¹

Монгол Улс, Улаанбаатар,

Шинжлэх Ухааны Академи, Хэл зохиолын хүрээлэн,

Аман зохиол судлалын салбар

Email: bayasgalant@mas.ac.mn,

<https://orcid.org/0009-0003-3900-1174>

Received: October 26, 2025 | **Accepted:** December 15, 2025 | **Published:** December 30, 2025

Хураангуй: Энэ өгүүлэлд Монгол, Шинжаанд амаар дэлгэрсэн “Жангар” туулийн Хаан Сийр бодонгийн бүлгийн дөрвөн хувилбарыг харьцуулж судлаад, эдгээр нь Ховогсайрын жангарч Шишинээн Бууралын дэг сургууль, Борталын Жин шианы жангарч Пүрэв тайжийн дэг сургууль гэсэн хоёр төрөлд хуваагдаж байна гэж үзжээ. Улмаар Ш.Буурал, Пүрэв нараас тус бүлгийг сурч, уламжлан дамжуулсан М.Пүрэвжсал, Б.Мөнтгөр, П.Рампил, Т.Ням нарын жангарчдын хэлсэн хувилбаруудад үйл явдлын талаар ямар өөрчлөлт гарсныг тодруулсан байна.

Тус бүлэг нь анх баатарлаг гэрлэлтийн сэдэвтэйгээр үүсжээ. Хаан Сийр хөвгүүн насны багад нь өндгөн сүй тавьсан бүсгүйгээ авахаар явж байх замдаа Улаадай гэгч хорон санаат баатарт итгэж гэнэдээд, унтаж байхдаа хөнөөгддөг. Улаадай, Хаан Сийрийн дүрд хувираад, сүйт бүсгүйг нь авах гээд очсон үед Хонгор ирж хортныг илчлэн, барьж аваад, Хаан Сийрийг амь оруулж, сүйт бүсгүйтэй нь гэрлүүлсэн тухай ерөнхий өгүүлэгдэхүүнтэйгээр үүссэн байна.

Энэ бүлэгт Хаан Сийр хөвгүүний гэрлэлтийг үзүүлсэн боловч, Хонгор баатрын алдар гавьяаны тухай бүлэг гэж болно. Тодруулбал, энэ бүлэг Хонгорын дүр Бумбын орныг төвхнүүлэгч, аврагч, хамгаалагч хэв шинжтэй болсон цаг үед буюу Хонгорын дүрийн хөгжилтэй уялдаж XVII-XVIII зуунд шинээр үүссэн гэж үзжээ.

Түлхүүр үг: дэг сургууль, Мишигдорж ван, Орно-Улаадай, урын сан

¹ © Т.Баясгалан, 2025

Two Types of Tradition in the “Khaan Siir Bodon” Chapter of the Jangar Epic

BAYASGALAN Tudev
Department of the Folklore Studies,
Institute of Language and Literature,
Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia

Abstract: *This article presents a comparative study of four versions of the Jangar epic chapter “Khaan Siir Bodong” which has been transmitted orally in Mongolia and Xinjiang. The study argues that these versions can be classified into two types traditions: the school of the Jangar performer Shishneen Buural of Khovogsair and the school of the Jangar performer Pürev Taij of Bortala. Furthermore, the article identifies changes in the plot as reflected in the versions recited by the Jangar performers M. Pürevjal, B. Möntgөр, P. Rampil, and T. Nyam, who learned and transmitted this chapter from Sh. Buural and Pürev.*

This chapter is believed to have originally emerged with the theme of heroic marriage. While traveling to marry the girl to whom he had been betrothed since childhood, Khaan Siir is deceived by a treacherous warrior named Orno-Ulaadai and is killed while asleep. Orno-Ulaadai then disguises himself as Khaan Siir and goes to claim the bride. At this point, Khongor arrives, exposes and captures the villain, restores Khaan Siir to life, and unites him with his bride forming the core narrative of the episode.

Although the chapter depicts the marriage of Khaan Siir, it may essentially be regarded as a chapter devoted to the heroic merits of Khongor. More specifically, the article suggests that this chapter emerged during the period when Khongor’s image had evolved into that of the founder, savior, and protector of the realm of Bumba, and that it was newly formed in connection with this development of Khongor’s character in the 17th–18th centuries.

Keywords: *tradition (school), Prince Mishigdorj, Orno-Ulaadai, repertoire*

Удиртгал

“Хаан Сийр бодонгийн бүлэг” бол Шинжааны “Жангар”-ын эртний уламжлалт бүлгийн нэг болно. Тус бүлгийг Монгол Улсын Ховд аймгийн Булган сумын ард Магсарын Пүрэвжал [торгууд, 1893-], Шинжааны жангарч Бадамын Мөнтгөр [торгууд, 1913-1996], Пэрлээгийн Рампил [торгууд, 1923-1994], Түгчигийн Ням [торгууд, 1947] нарын жангарчид хэлжээ. Тархац, уламжлалаас үзэхэд торгууд жангарчдын урын санд үүсэж, Ховогсайр, Бортал, Баянголын торгуудуудын дунд ам дамжин уламжлагдаж ирсэн байж болно. Бидний үзэж буйгаар барагцаалбал, XVIII зуунд үүссэн бололтой. Т.Нямын хувилбараас бусад гурван хувилбарыг профессор Ж.Ринчиндорж харьцуулж үзээд “адил байхын хамт адил биш газар бас олон байна” (Ринчиндорж, 2010: 92) гэжээ. Тиймээс дээрх бүлгүүдийг лавшруулан судлах шаардлагатай. Энд дээрх дөрвөн бүлгийг үйл явдал, өгүүлэмж, байгууламжаар нь харьцуулж судлаад:

Нэгдүгээрт, Ховогсайрын жангарч Шишнээн Бууралын дэг сургууль

Хоёрдугаарт, Борталын Жин шианы жангарч Пүрэв тайжийн дэг сургууль гэсэн хоёр төрөлд хуваагдаж байна гэж үзлээ.

Хоёр дэг сургуульд хамаарах Хаан Сийрийн бүлгүүдийг харьцуулж үзэхэд, зарим баатрын нэр, үг хэллэг, бүтэц, агуулгаараа ялгаатай. Жангарч Бууралаас уламжлагдсан бүлгүүд гэрлэлт, дайн тулааны хосолмол сэдэвтэй, угсарсан бүтэцтэй байдаг. Пүрэв тайжаас уламжлагдсан бүлгүүд гэрлэлтийн сэдэвтэй, дан бүтэцтэй байдаг.

Нэг. Шишнээн Бууралын дэг сургууль ба түүний залгамжлагчдын урын сангийн онцлог

Одоогийн Шинжааны Тарвагатай аймгийн Ховогсайр монголын өөртөө засах шиан, хуучнаар Үнэн сүсэгт хуучин торгуудын хойд замын чуулганы ард иргэдийн дотор олон жангарч байсны нэг нь Шишнээн Буурал [1800 оны сүүлч, 1900 оны эхэн үед амьдарч байсан] юм. Энэ хүн бол Донровцэдэн вангийн тусгай жангарч байсан бөгөөд “ясны жангарч” цолтой (Таяа, 2010: 58) байжээ.

ШУА-ийн Хэл зохиолын хүрээлэнгээс томилогдсон шинжилгээний ангийнхан 1978 онд Ховд аймгийн Булган сумын ард Магсарын Пүрэвжалаас Жангар туулийн “Хаан Сийрийн бүлэг” гэдэг найман зуун мөр шүлэг бүхий тууль бичиж авчээ. Энэ бүлгийн тухай М.Пүрэвжал ярихдаа: “Торгууд вангийн хошууны Мишигдорж ван Ховогсайрд Жангарын түүх намтар хэлдэг сайн жангарч байна гэдгийг сонсоод, нэг хүн илгээж: -Манай хошуунд ирж Жангарын тууль хэлж өгнө үү? гэжээ. Мишигдорж вангийн элч, Буурал жангарч гэдэг хүн дагуулж иржээ. Тэр хүн Жангарын найман бүлэг хэлсэн. Мишигдорж ван Буурал жангарчийг хөхиүлэн сайшааж нэг морь, нэг дээлийн торгоор урамшуулсан гэдэг. Буурал жангарчаас олон хүн Жангарын тууль сонсож, торгууд хошуунд Жангар дэлгэрсэн юм. Энэ Хаан Сийрийн тууль бол Жангарын туулийн тийм нэг бүлэг болно” (Цолоо, 1982: 27) гэжээ.

Эрдэмтэн Т.Жамц энэхүү Буурал гэдэг нэртэй жангарчийг ХХ зууны эхэн хүртэл Ховогсайрт Жангар хэлж нэрд гарсан Шишнээн Буурал гэдэг хүн мөн бөгөөд түүний шавь “холбир” Баяр, Шарын Насан, Аанайн Нээхэй нарын зэрэг жангарчаас П.Рампил Жангар сурсан (Жамц, 1997: 369) гэжээ.

Дээрх мэдээ баримтуудаас үзвэл, Шишнээн Буурал гэдэг жангарч найман бүлэг хайлдаг, түүний мэддэг бүлгүүд “холбир” Баяр, түүний шавь Пэрлээгийн Рампилаар дамжин бидний үед уламжилж ирсэн байна. П.Рампил 17 бүлэг хэлсний нэг нь “Хаан Сийр хөвгүүний бүлэг” юм. Энэ бүлгийг Рампил 1977 онд хэлжээ.

Ингэхээр бидний гар дээр “Хаан Сийрийн бүлэг”-ийн Ш.Бууралаас шууд уламжилсан М.Пүрэвжалын хувилбар ба Баяр, Рампил гэсэн хоёр үеийн хүнээр дамжин уламжилсан бас нэг хувилбар байна. Пүрэвжалаас 1978 онд тэмдэглэж авсан бол, Рампилаас 1977 онд тэмдэглэж авчээ. Ам дамжих явцдаа өөрчлөгдсөн гэж үзвэл, Баяр, Рампил гэсэн хоёр хүний урын сангаар дамжсан тэр эх (текст) нь илүү өөрчлөгдсөн байх магадлал бий. Юутай ч Хаан Сийрийн бүлгийг Ш.Буурал ямар агуулга, үйл явдлын хүрээнд хэлдэг байсан нь, дараа үеийн хүмүүсээр дамжин уламжлахдаа хэрхэн өөрчлөгдөв гэдгийг мэдэх боломж байна.

Шууд уламжилсан учраас Буурал жангарчийн хэлсэн хувилбартай хамгийн ойролцоо нь М.Пүрэвжалын хувилбар байх ёстой. Пүрэвжалыг 13 настайд нь

Мишиг вангийн өргөөний бийчин (биелгээч) Даш гэдэг хүнд шавь болгосон (Катуу, 2013: 134) гэснээс үзэхэд, 1905 оны орчим энэ шавь орох үйл явдал болжээ. Ингээд барагцаалж үзвэл, 1905-1921 оны хооронд Мишигдорж вангийн өргөөнд Буурал жангарч уригдаж, Жангар хайлжээ. Пүрэвжал нь Буурал жангарчаас сурсан Хаан Сийрийн бүлгийг жүжиг болгон найруулж, тоглуулж байсан гэнэ (Катуу, 2013: 134).

Пүрэвжал, Рампил, Мөнтгөр, Ням гэсэн дөрвөн жангарчийн хэлсэн эхүүдийг үйл явдлаар нь харьцуулж үзэхэд, хамгийн бүрэн бүтэн агуулгатай нь Пүрэвжалын хувилбар байна. Рампилын хувилбарын эхэн хагас нь дутуу, Мөнтгөр, Ням нарын хэлсэн хувилбарууд төгсгөл хэсгээсээ дутуу байна [Пүрэвжалын хувилбартай харьцуулбал]. Баатруудын нэрийн тухайд, туулийн гол баатар Хаан Сийр, түүний эцэг хаан [Хар-Арслан, Сар-Арслан], сөргөлдөгч дүрийн нэр [Орно-Улаадай¹, Улаадай, Чирмандай-Улаан] харьцангуй тогтвортой буюу ойролцоо, харин гол баатрын сүйт бүсгүй, түүний эцэг хааны нэр [Зуувчийн цагаан хааны охин Зурмал Цагаанбилиг, Номтөгсөгч хааны охин Нарныгэрэл, Мөнгөн хааны охин Мөндөлгуа] ихээхэн солигдож өөрчлөгджээ. Түүнчлэн Алтанцээж, Амцагаан нэртэй шивэгчний дүр Рампилын хувилбарт огт дурдагдахгүй.

Үйл явдлын байгууламж, бүтцийн хувьд Пүрэвжалын хувилбар:

1. Эхлэл [Жангарын удам гарал, нутаг орон, баатрууд, Жангарт байшин барих, найр]
2. Алтанцээж уулан дээр гарч алсын бараа харж явж байгаад Хаан Сийр, Орно-Улаадай хоёртой тааралдсан;
3. Хаан Сийр, Орно-Улаадай хоёр явж байгаад, Орно-Улаадай нь Хаан Сийрийг унтаж байхад бэлхүүсээр нь тас цавчиж алсан;
4. Орно-Улаадай, Мөнгөн хааныд очиж Мөндөлгуаг авах гэхэд Мөндөлгуа татгалзсан учир эцэг нь уурлаж харгис хэрцгийгээр шийтгээд, түүний дүү Харнүдэнг Орно-Улаадайтай гэрлүүлсэн;
5. Хонгор баатар, мангаст алба төлөхөөр явж байгаад, тас цавчуулсан Хаан Сийрийн цогцостой тааралдаж, амь оруулж орхиод явсан;
6. Хонгор, Мөнгөн хааны нутагт хүрч ирээд, Мөндөлгуатай уулзаж учир явдлыг мэдээд, Мөнгөн хааныд очиж Орно-Улаадайд барьж хүлээд, Хаан Сийр, Мөндөлгуа хоёрыг уулзуулсан;
7. Хонгор, Хаан Сийр хоёр нутагтаа буцаж ирэхэд, арван хоёр толгойтой Атигар хар мангас довтолж ирсэнтэй Жангар тулалдаж байсан. Хоёр баатар мангасын цэргийг хядан устгаж, нутаг орноо төвхнүүлж амар сайхан жаргасан.

Дээрх товчоолж үзүүлсэн хэсгүүдээс эхний гурван хэсгийн үйл явдал П.Рампилын хувилбарт байхгүй. Тиймээс П.Рампил энэ бүлгийг анх сурснаа тэр байдлаар өөрчлөлгүй хэлсэн үү, эсвэл ийнхүү өөрчилж хэлсэн үү гэдэг асуулт гарна.

¹ Ж.Цолоогийн хэвлүүлсэн “Монгол ардын баатарлаг тууль” (1982) номд энэ нэрийг Орно-Улаандай, Орно-Улаадай гэж хоёр өөрөөр бичжээ. Ихэвчлэн Орно-Улаадай гэсэн байх тул олонтоо дурдагдсан хэлбэрээр жигдэлж бичлээ.

Пүрэвжалын хувилбарт Атигар хар мангастай тулалдсан тухай үйл явдал нэлээд товчхон байдаг бол, Рампилын хувилбарт гучин таван толгойтой Гудман хар мангас, хорин таван толгойтой Хотгор хар мангасуудтай тулалдсан тухай дэлгэрэнгүй үйл явдал гардаг. Үүгээрээ Пүрэвжалын хувилбар бол Бууралын хэлсэн тэрхүү эхийг сэдэв, үйл явдал, бүтцийн хувьд уг байдлаар нь хадгалсныг харуулж байна. Бид өмнө нь Пүрэвжалын хувилбарыг Мөнтгөрийн хувилбартай харьцуулж үзээд, Атигар хар мангасыг дарсан үйл явдлыг Пүрэвжал өөрөө нэмсэн байна (Баясгалан, 2010: 76) гэж дүгнэсэн нь ташаарсан болохыг энд залруулж байна. Учир нь Хонгор, Хаан Сийр хоёр Бумбын оронд хүрч ирэхэд, их дайн тулаан өрнөж байсан тухай үйл явдал жангарч Бууралын хувилбарт байсан гэдэг нь Рампилын хувилбараар нотлогдож байна.

Эндээс дүгнэхэд, жангарч Ш.Буурал бол Хаан Сийрийн бүлгийг нэлээд уртавтар эхлэл хэсэгтэй, 1) Хаан Сийр хөвгүүний гэрлэлтийн адал явдал, 2) Жангарын нутаг оронд Хонгор баатрыг эзгүйчилж довтолж ирсэн мангасуудтай тулалдсан тухай үйл явдал бүхий гэрлэлт, дайн тулааны хосолмол сэдвийн хүрээнд хайлдаг байжээ. Харин “холбир” Баяр, П.Рампил нарын жангарчид Бууралын хэлсэн тус бүлгийн эхэн хэсгийг орхин хэлж уламжлуулжээ.

Пүрэвжалын хувилбарт Жангарын уг удмыг тоочсон дүрслэлээс үзэхэд, Буурал жангарчийн урын сан бол халимаг “Жангар”-ын нөлөөгүй, бүс нутгийн онцлогийг хадгалсан байжээ. Буурал жангарч тус бүлгийг хэлэхдээ Жангарын ордон байшинг барьж, баатрууд цуглаж найр наадам хийсэн тухай дэлгэрэнгүй оршил буюу эхлэл хэсэгтэй хэлдэг байжээ. Шинжаанд дэлгэрсэн Нарандалай хаан, Малайхавх хаантай тулалдсан тухай эртний уламжлалт бүлгүүд, Халимаг, Монголд дэлгэрсэн хуучны бүлгүүд нь сүм суварга босгосон, хаврын сарыг тэмдэглэж найр наадам хийсэн тухай уртхан эхлэлтэй байдаг. Чухам эдгээртэй Хаан Сийрийн бүлэг ижил бүтэц, агуулгатай байсныг мэдэж болно.

“Хаан Сийрийн бүлэг”-г гарч буй Алтанцээжийн дүр нь Борталын жангарч Ш.Пүрэвжавын хэлсэн бүлгүүдэд гардаг Алтанцээжийн дүртэй ижил, харуул хардаг алба үүрэгтэй байгаа нь Шинжааны “Жангар”-ын дүрийн хэв шинжийн онцлог мөн.

Пүрэв тайжийн дэг сургууль ба түүний залгамжлагчдын урын сангийн онцлог

Шинжааны Борталын аймгийн Жин шианы харьяат, тайж язгуурт Пүрэв гэдэг хүн Хаан Сийр бодонгийн бүлгийг уламжлуулахад чухал үүрэг гүйцэтгэжээ. Тэр бээр өөрийн шавь Мөнтгөрт хэрхэн Жангар цээжлүүлсэн талаар профессор Д.Таяа бичсэн нь: “Жингийн бэйлийн Бэгрэс сумын Пүрэв тайж бээр шавь Мөнтгөртөө ажлынх нь чөлөөгөөр анх тод монгол үсэг зааж өгөхөөр сайн сурч өгөхгүй тул: -За, чи үсэг сурах дургүй бол миний хэлдэг ‘Жангар’-ыг сурч ав гээд ‘Жангар’-аа зааж өгсөн байна. Түүндээ Пүрэв тайж: -Би хэрэв аясыг нь оруулаад хэлбэл, та нар үгийг нь мэдэхгүй. Та нарт сайн ойлгогдохын төлөө үгчлэн хэлье гэж 32 бүлэг бүхий тод монгол үсгийн гар бичмэл ‘Жангар’-ын судраа үзэж уншаад, уянгалуулан ярьж өгч цээжлүүлдэг байжээ. Энэ тухай Мөнтгөр: -Пүрэв тайж ‘Би 32 бүлэг Жангар мэднэ’ гэдэг билээ. Тэр асхан болгон надад нэг бүлэг ‘Жангар’ хэлж заадаг билээ. Өмнө асхан заасан ‘Жангар’-ыг нь маргааш нь сайн хэлж эс чадвал чихийг минь чанга мушгиж, дахин заагаад, тэр бүлгээ хэлээд

сургадаг билээ” (Таяа, 2010: 240) гэжээ. Ингээд Мөнтгөр, 32 бүлэг ‘Жангар’-ыг долоон өдөр шөнө хэлдэг Пүрэв тайж гэдэг жангарчаас долоо найман бүлэг ‘Жангар’ сурчээ (Жамц, 1997: 439).

Мөнтгөрийн сурсан долоо найман бүлгийн нэг нь энэхүү “Ханцуй болсон бууралтай Хаан Суурь бодонгийн бүлэг” юм. “Сийр” (sir) гэдэг үг бол “арслан” гэдэг утгатай түрэг гаралтай үг бөгөөд “Хаан Сийр” гэдэг үг бол “хаан арслан”, “арслан бодонгуудын хаан” гэдэг утгатай үг ба зарим хувилбарт авиа ондоошиж “Суурь” болсон ажээ (Жамц, 1997: 386). Мөнтгөр найм орчим наснаасаа Жангар сурч эхэлсэн гэдэг нь 1921 оны орчимд хамаарна. Мөнтгөрийн хэлсэн хувилбарт Э.Овлайн Жангарын нөлөө байгаа гэдэг нь Жангарын удам гарлыг тоочсон хэсэг болон бусад олон зүйлийн жишээнээс мэдэгдэнэ. Хэдий тийм боловч Мөнтгөрийн энэхүү хувилбар бол баатруудын нэр ба өгүүлэгдэхүүний хувьд Хаан Сийрийн бүлгийн бие даасан уламжлал мөн. Мөнтгөрийн энэ хувилбар ихэвчлэн 2-4 шадаар толгой холбож шүлэглэсэн, хэл найруулга, үг хэллэг ойлгомжтой, цэгцтэй, тус бүлгийн анхдагч үйл явдлын хүрээнд уламжлагдсан, уран сайхны хувьд нэлээд чансаатай хэлсэн хувилбар болно.

Хаан Сийрийн бүлэг бол гэрлэлтийн сэдэвтэйгээр анх үүсжээ. Тодруулбал, Хаан Сийр хөвгүүн насны багад нь өндгөн сүй тавьсан бүсгүйгээ авахаар явж байх замдаа танилцсан Улаадай гэгч хорон санаат хүнд итгэж гэнэдээд, унтаж байхдаа хөнөөгддөг. Ингээд Улаадай, Хаан Сийрийн дүрд хувираад, сүйт бүсгүйг нь авах гээд очсон үед Хонгор ирж хортныг илчлэн, барьж аваад, Хаан Сийрийг амь оруулж, сүйттэй нь гэрлүүлсэн тухай ерөнхий өгүүлэгдэхүүнтэйгээр үүссэн байна. Харин жангарч Ш.Бууралын урын санд Хонгор, Хаан Сийрийг гэрлүүлээд, хамт нутагтаа буцаж ирэхэд, мангасууд довтлон ирээд, тулалдаж байсан тухай өгүүлэмж нэмэгджээ.

Мөнтгөрийн хэлсэн бүлэгтэй нэг уламжлалд хамаарах хувилбар бол Баянгол аймгийн Хижин шианы Хүнхэс сумын харьяат Т.Ням хэлсэн “Хаан Сийр бодонгийн бүлэг” юм (Баянголын Жангар, I. 2015: 566-601). Сийр бодонгийн сүйт бүсгүйг М.Пүрэвжалын хувилбарт Мөнгөн хааны охин Мөндөлгоо гэдэг бол Нямын хувилбарт Мөнхдалай хааны охин Мөндөлгоо гэдэг нь их сонирхолтой. Үүнийг эс тооцвол, Нямын хувилбар ерөнхий өгүүлэгдэхүүний хувьд Мөнтгөрийн хэлсэн хувилбартай үндсэндээ ижил. Харин үйл явдлын зарим нэг хэсгийг орхисон байдаг. Жишээлбэл, Сийр бодон аян замдаа Улаадаитай тааралдаж, тулалдан дийлээд, үнэнч байх ам тангаргийг нь авч амь хэлтрүүлээд, хамт цааш явдаг. Хоёул эхний удаа үдлэх зуур Сийр бодонг унтаж байхад, Улаадай алахаар цавчсан ч илд нь эс даадаг. Ингээд хоёр дахь удаа үдлэх зуур Сийр бодонг унтаж байхад, илдийг нь авч цавчиж хороодог. Тэгвэл Т.Нямын хэлсэн хувилбарт Улаадай эхний удаа шууд цавчиж алсан гэдэг. Түгчигийн Ням болбол тод, худам үсэг мэддэг. Тав зургаан наснаасаа эхэлж авга эцэг Төмгөд болон нутгийн жангарч нараасаа Жангар ба бусад үлгэр, тууль хайлж хэлэхийг сурсан гэнэ (Баянголын Жангар, I. 2015: 1025).

Ням, Мөнтгөр, Рампил нарын хувилбарт Хаан Сийр бодонг Жангарын зээ гэжээ. Үүнээс үзэхэд, Хаан Сийр бодонгийн бүлэг нь Жангар, Хонгор нарын залгамж үеийн дүрүүд үүсэхтэй ойролцоо цаг үед үүссэн бололтой. Хаан Сийр, Хошууны дүр ба Монголд дэлгэрсэн Хавхан Харсоёогийн бүлгүүдэд гардаг Бормагнай хүүгийн дүрүүд ойролцоо цаг үед үүссэн гэж үзэж байна.

Дүгнэлт

Нэг талаар энэ бүлэг Хаан Сийр хөвгүүний гэрлэлтийг үзүүлсэн боловч, нөгөө талаар Хонгор баатрын алдар гавьяаны тухай бүлэг юм. Хонгор баатар албан татвараа төлөхгүй, салан тусгаарлах хандлага гаргаж байгаа овог аймгийг очиж номхруулаад, буцаж явах замдаа гэнэн балчир насны эрхээр дайсандаа мэхлэгдэж хөнөөгдсөн Сийр хөвгүүнийг амь оруулан сэхээж, гэр бүлтэй болгож өгөөд, буцаад иртэл, Хонгорыг эзгүйчилж Бумбын орныг эзэлж авахаар мангасууд довтлон ирж, Жангарынхан чухам сүйрэлд ороод байхад нь Хонгор амжиж ирж аварсан тухай агуулгатай. Тиймээс энэ бүлэг бол Хонгорын дүр Бумбын орныг төвхнүүлэгч, аврагч, хамгаалагч хэв шинжтэй болсон цаг үед шинээр үүссэн байна. Хонгорын дүрийн хөгжлийн энэ үе бол XVII-XVIII зуунд хамаарч байгаа юм.

Хонгор баатар өөрийн цаг үедээ Бумбын орны хортон дайснуудыг дараад зогсохгүй, дараа үе буюу залгамж үеийнхээ хүмүүсийн гэр бүлийг хүртэл зохиож өгдөг, овгийн ахмад, өрхийн тэргүүний маягтай зохицуулагчийн үүргийг гүйцэтгэх үзэгдэл Хөр Хар-Усны торгууд, Ховогсайрын торгууд “Жангар”-ын уламжлалд бий болсон байна. Жишээлбэл, Хар-Ус шианы жангарч Ж.Дэлхэйн хэлсэн “Хөгшин Жангарын бүлэг”-т Хонгор, Хартэвэгийг даран сөнөөгөөд, найр жаргал хийгээд дөнгөж өндөрлөтөл, Талын хааны хөвгүүн тавтай [taba-tai] Жилмэн-Улаан гэгч эхнэр авна гэж уйлаад, түүнийг Хонгор дагуулан явж, замдаа тааралдсан нэгэн хааны хоёр охины нэгийг эхнэр болгон авч өгсөн тухай өгүүлдэг нь чухамдаа Сийр хөвгүүний бүлгийн нэлээд мартагдсан гэмээр хэлбэр байна. Эсвэл Сийр хөвгүүний бүлэг үүсэх анхны хэлбэр ч байж болно.

Сийр хөвгүүний бүлгийн Мөнтгөрийн хувилбарт гардаг Чирмандай-Улаан, Дэлхэйн хувилбарын Жилмэн-Улаан хоёр бол гарал үүслээрээ холбоотой. Рампил, Ням нарын хувилбарт Улаадай нэрээр гардаг. Улаадайн гэрлэсэн хүүхэн бол нэг хааны эгч, дүү хоёр охины нэг байдаг. Ингээд үзэхэд, хэдий үйл явдлын хувьд их ондоошсон боловч үндсэн өгүүлэмж нь ижил байна. Тиймээс Хар-Ус шианы нутагт Сийр хөвгүүний бүлэг уламжлагдаж байжээ.

Ном зүй

- Баянголын Жангар. I.** (2014) *Хижин шианы боть*. Ерөнхий эрхлэн найруулагч Б.Мөнх, Ма Шиюн Фу, Амжилт, Нарангоо. Өвөр Монголын соёлын хэвлэлийн хороо. 2014. [Bayangoliin Jangar. III. Yerunkhii erkhiilen nairuulagch B.Munkh, Ma Shiyun Fu, Amjilt, Narangoo [Jangar in Bayangol province]. Committee of Cultural printing in Inner Mongolia: 2014.]
- Баясгалан, Т.** (2010). “*Жангар*” туулийн хэв шинжийн харьцуулсан судалгаа. Улаанбаатар: Bibliotheca oiratica. XVI. “Соёмбо принтинг” ХХК. [Bayasgalan, T. “Jangar” tuuliin khev shiniin kharitsuulsan sudalgaa [Comparative study of the “Jangar” epic] Ulaanbaatar: Soyombo printing. 2010.]
- Жамц, Т.** (1997). *Тууль “Жангар”-ын учир*. Үрэмч. Шинжааны ардын хэвлэлийн хороо. Тод үсгээр. 516 х. [Jamts, T. Tuuli “Jangar”-iin uchir. [About the epic of the Jangar] Committee of Folk printing in Xinjian. 1997.]

- Катуу, Б.** (2013). *Монгол туургатны туульчид*. Улаанбаатар: Редактор Д.Цэрэнсодном, С.Юндэнбат. 237 х. [Mongol tuurgatnii tuulichid [Epic tellers in Mongol tribes]. Ulaanbaatar: 2013.]
- Ринчиндорж, Ж.** (2010). *Туульчид, хуурчдын намтар, бөө мөргөлийн яруу найраг*. Үндэстний хэвлэлийн хороо. 498 х. Уйгуржин монгол бичгээр. [Tuulich khuurchidiin namtar, böö mörgöliin yruu nairag. [Biographies of epic singers and fiddlers and poetry of shamans] Ündestnii khebleliin khoroo. 2010]
- Таяа, Д.** (2010). *Шинжааны жангарчийн уламжлал судлал*. Улаанбаатар. Bibliotheca Oiratica. XIX. Эрх. хэвл. На.Сүхбаатар. “Соёмбо принтинг” ХХК. Улаанбаатар. [Studies tradition of Jangar epic tellers in Xinjian. Ulaanbaatar: Soyombo printing. 2010.]
- Таяа, Д.** (2013). Аримпилын “Жангар” хорин гурван бүлэг. “Жангар”-ын эрдэм шинжилгээний текст-3. Д.Таяа цуглуулан, буулгаж, тайлбарлав. Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо. Уйгуржин монгол бичгээр. [Arimpiliin “Jangar”-iin 23 бүлэг [23 chapters performed by Arimpil. Committee of Cultural printing in Inner Mongolia: 2013.]
- Цолоо, Ж.** (1982). *Монгол ардын баатарлаг тууль*. Улаанбаатар: Улсын хэвлэлийн газар. [Tsoloo, J. Mongol ardiin baatarlag tuuli [Tsoloo, J. Mongolian folk heroic epics]. Ulaanbaatar: State Publishing House. 1982.]



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>